

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “УСДУ” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 242 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, хоёрдугаар хавсралтаар баталсан тарифыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “УСДУ” ОНӨААТҮГ (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн “Тариф батлах тухай” 154 дүгээр тогтоолын хавсралтын 1,2 дугаар мөрөнд заасан Төсөвт байгууллагын халаалтын тарифыг, 5 дугаар мөрөнд заасан төсөвт байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулааны тарифыг тус тус хүчингүй болгосугай.

4. Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн “Тариф батлах тухай” 154 дүгээр тогтоолыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)	
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	3,360.0	
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	40,487.0
		Тогтмол	Төг/м ³	2,281.0
3	Төсөвт байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м ³	6,656.0	

--oOo--

*Эрчим хүчний зохицуулах хорооны
2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН
ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ ӨРХӨД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)	
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,723.0	
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	32,805.0
		Тогтмол	Төг/м ³	1,848.0
3	ҮААНБ-ын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м ³	6,656.0	
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, "00"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	1,120.0	
5	Орон сууцны халаалт	Хувьсах	Төг/ГЖ	13,496.0
		Тогтмол	Төг/м ³	760.0
6	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Төг/хүн	5,600.0
		Эзлэхүүнээр	Төг/м ³	2,800.0
		Хэмжүүрээр хувьсах	Төг/ГЖ	26,973.0
		Хэмжүүрээр тогтмол	Төг/м ³	1,591.0
7	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м2 хүртэлх талбайтай айл өрх	Төг/сар	4,200.0
		41 м2-ээс 80 м2 хүртэлх талбайтай айл өрх	Төг/сар	7,000.0
		81 м2-ээс дээш талбайтай айл өрх	Төг/сар	14,000.0